



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/156

Булган сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан ЕБС-ийн англи хэлний ленгифоны танхим тохижуулах (Хутаг-Өндөр сум, Хангал сум Хялганат тосгон, Булган сумын 1, 2, 3 дугаар сургууль) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:

- Д.Батцогт

(Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Гишүүд:

- М.Мөнхбат

(Статистикийн хэлтсийн дарга)

- Б.Мягмарсүрэн

(Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл: - Б.Туяа

(Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: - Б.Баярцэнгэл

(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Төндөр шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Д.Батцогт)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010111